



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 8/13

Мандалговь

Г Ажлын хэсэг шинэчлэн томилох тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03 сарын 12-ны өдрийн А/121 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ДЭМБ-ын Зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц PEN/HEARTS-ийн хүрээнд нэвтрүүлэх зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (МонПЭН)-ыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Гишүүд: Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

Анхан шатны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эмийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн

Эм, эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн

Мэдээлэл сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны эмч

Нэгдсэн эмнэлгийн дотоод шүүрлийн эмч

Нарийн бичиг: Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (МонПЭН)-ыг анхан шатны тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг сар бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.АЛТАНТӨГС*